

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

(2013 оны 1-р улиралд)

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 10.1 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 2.0 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 8.4 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.
Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 7.7 тэрбум төгрөг хүрсэн байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хас, Хадгаламж, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 52.1 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 5.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 26.0 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 0.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 7.6 хувь болох 75.8 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.4 хувь болох 75.7 мянган төл бойжиж байна.

Оны эхний малын 0.4 хувь болох 9.9 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.6 хувьтай байна.

Нийт хорогдлын 48.2 хувь нь ямаа, 41.7 хувь нь хонь эзэлж байна.

Түмэнцогт, Эрдэнэцагаан сумдаас бусад сумдын оны эхний малын 0.1-1.2 хувь болох 3.7 мянган толгой мал хорогдоод байгаа нь нийт хорогдлын 36.8 хувийг эзэлж байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 8.3 тэрбум төгрөг болж, урьд оны мөн үеийнхээс 1.4 тэрбум төгрөгөөр доогуур байна.

Оны үнээр 33.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 5.3 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс нарийн боов, хиам, дулаан, яндан, пийшин, шургуулга, түлээний авдар, лааз, ваань, угаалтуур, түмпэн, хогийн утгуур, савар, галын хайч, том дээл, хантааз, сандал, хаалганы үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ТЭЭВЭР, ХОЛБОО: Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 17.7 сая.тн.км-ийн ачаа эргэлт, 15.3 сая.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж, 2.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 115.6 сая төгрөгт хүрсний дотор 48.1 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 760 байна.

VI. СОЁЛ: Соёл: Хөгжимт жүжгийн театр 2.4 мянган үзэгчдэд 6 тоглолтоор үйлчилж 5.8 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Музей: 1.8 мянган үзмэрээр 0.2 мянган хүнд үйлчилж, 240 мянган төгрөгийн орлого олжээ.

Нийтийн номын сан: 8.5 мянган уншигчдад 44.5 мянган номоор үйлчилсэн байна.

VII. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 3-р сард оны эхнээс 1.7 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 4.7 хувиар өсч түүн дотор саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколадаас бусад нэр төрлийн үнэ 1.9-11.8 хувиар өссөн байна.

Мөн боловсролын үйлчилгээ, холбоо, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнээс бусад бүх бүлгийн үнэ, тариф 0.1-5.7 хувиар өссөн байна.

VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1.8 тэрбум төгрөг болж, төлөвлөгөө 4.7 хувиар давж биелэв. Сайн дурын даатгуулагчид 42.4 сая төгрөгний шимтгэл оруулсан байна. 6218 өндөр настанд 3.6 тэрбум төгрөгийн тэтгэврийг бүрэн олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 0.7 тэрбум төгрөгийг 3.8 мянган иргэнд, улсын төсвөөс 0.9 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 6.1 мянган иргэнд тус тус олгосны дотор хүний хөгжил сангаас 0.1 тэрбум, төгрөгийг 85 иргэнд олгосон байна.

IX. ЭРҮҮЛ МЭНД: Оны эхний 3 сард 295 эх амаржиж, 297 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна.

Халдварт өвчнөөр 396 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 240-өөр олон байгаа бөгөөд гахай хавдар, салхинцэцэг, тэмбүү, заг, трихоминиаз зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

X. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 831 болж, өнгөрсөн оны мөн үеэс 61-н хүнээр буурсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 74.4 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 24.5 хувь нь дээд, 3 хувь нь тусгай дунд, 41.2 хувь нь бүрэн дунд, 5.4 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 3 сард 94 хүн шинээр бүртгүүлж, 37 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 36 хүн ажиллаж байна.

XI. ГЭМТ ХЭРЭГ: Оны эхний 3 сард 79 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 30-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 6 хүн нас барж, 26 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 16,1 сая төгрөгийн хохирол учирсны 63,5 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 38 хүн холбогдон сэжиглэгдсэний 34.2 хувь нь согтуугаар, 15.8 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 798 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 60 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 38 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

XII. МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ: Энэ онд 13 суманд 4 даатгалын нэгжийн 118 төлөөлөгч ажиллах эрхээ аваад байна.

Эхний 3 сарын байдлаар малын индексжүүлсэн даатгал хийгдээгүй байна.

XIII. ДААТГАЛ: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 14.9 сая төгрөг болж, төлөвлөгөө нь 26.1 хувиар буурсан байна. 127 хүнд 17,8 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 0.3 сая, гэнэтийн осолд 1.0 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 1.6 сая, жолоочийн хариуцлагад 14,0 сая, иргэний эд хөрөнгөд 0,9 сая төгрөгийг тус тус олгожээ.

XIV. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 6927 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 6598 иргэнд 615.05 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байгаагийн дотор энэ оны эхний 3 сард 41 иргэн өргөдөл гаргаж, 41 иргэнд 2.89 га газрыг өмчлүүлэх шийдвэр гаргасан байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

